

**“ХААН БАНКНЫ НЭРЭМЖИТ ШИНЭ ОЮУТНЫ  
ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР 2019-2020”****ӨРГӨДЛИЙН МАЯГТ****Хөтөлбөрийн зорилго:**

ХААН Банк Сангийн боловсролыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд сурлагын амжилт, нийгмийн идэвх зүтгэлээр тэргүүлж буй, хувь хүний болон нийгмийн ур чадвар сайтай, цаашид суралцах хүсэл эрмэлзэлтэй хэдий ч санхүүгийн бэрхшээлийн улмаас их дээд сургуульд элсэн суралцахад хүндрэлтэй байгаа, орлого багатай өрхийн **ЕБС-ийн 12-р ангийг төгсөж** буй 60 хүүхдийг шалгаруулж, 2019-2020 оны хичээлийн жилд сургалтын төлбөрийн тэтгэлгийн тодорхой хувийг олгож, тэдний цаашид сурах хүсэл эрмэлзлэлийг дэмжин оюуны хөрөнгө оруулалт хийнэ.

**Хөтөлбөрийн хамрах хүрээ:**

ХААН Банк Сангаас 12 дахь жилдээ хэрэгжүүлж байгаа тус хөтөлбөрийн хүрээнд Монгол улсын 21 аймаг, Замын-Үүд, Зүүнхараа, УБ хотын Багануур дүүргийн ЕБС-ийн нийт **60 төгсөх ангийн** сурагчийг шалгаруулна.

**Хөтөлбөрийг зарлах:**

Хөтөлбөрийг **2019 оны 04-р сарын 16-ны өдрөөс** олон нийтэд нээлттэй зарлана.

**Материал хүлээн авах хугацаа:**

Өргөдлийн материалыг **2019 оны 04-р сарын 16-аас 5-р сарын 03-ны өдрийг дуустал** хүлээн авна.

**Материал хүлээн авах газар:**

Өөрийн оршиж буй харьяа аймаг, сумын ХААН Банкны салбар, тооцооны төв дээр битүүмжлэн хүлээн авна.

**Холбоо барьж, дэлгэрэнгүй мэдээлэл авах:**

- ХААН Банкны лавлах **1800-1917** (энгийн утасны тарифаар),
- Төв Банкны **11-332333** (дотуур утас 4237, 3570)
- [www.khanbank.com](http://www.khanbank.com) вэбсайт хаягаар тус тус хүлээн авна.

**Шалгаруулалтын дүнг зарлах :**

ХААН Банкны нэрэмжит шинэ оюутны тэтгэлэгт хөтөлбөрт шалгарсан **60** сурагчийн нэрсийг 2019 оны 05-р сарын 28-нд ХААН Банкны [www.khanbank.com](http://www.khanbank.com) /[www.khanbank.com/facebook/](https://www.khanbank.com/facebook/) **вэбсайт болон өдөр тутмын сонингуудаар** мэдээлнэ.

**Тэтгэлгийн хэмжээ:**

**1,000,000 төгрөг**

**Сонгон шалгаруулах үндсэн үзүүлэлт:**

1. 2019 онд Ерөнхий Боловсролын сургуулиа дүүргэх 12-р ангийн сурагч байх
2. Сурлагын голч дүн нь “В” буюу 85%, түүнээс дээш байх
3. Ахлах ангидаа (11-12-р анги) улс, аймаг, хот, дүүргийн олимпиад болон уралдаан тэмцээнд амжилт гаргасан байх
4. Нийгэм олон нийтийн ажилд тэргүүлэн оролцдог бол давуу тал гэж үзэх
5. Тухайн сурагч цаашид их дээд сургуульд дэвшин суралцах хүсэл эрмэлзэлтэй байх
6. Өрхийн амжиргааны түвшин зэргийг харгалзан үзэж сонгон шалгаруулалтыг шат бүрт явуулна.

**Тэтгэлэг хүсэгчийн бүрдүүлэх материал:**

1. Анкет (маягтын дагуу, Хавсралт 1) , цээж зураг (3x4 хэмжээтэй)



2. Ахлах ангийн буюу 11-р ангийн эцсийн дүн, 12-р ангийн эхний хагас жилийн **дүнгийн жагсаалт** (энэхүү жагсаалт нь сургуулийн тамга тэмдэг, холбогдох удирдлагын гарын үсэг бүхий албан бичиг байна. Гараар бичсэн, дүн дутуу дүнгийн жагсаалтыг тооцохгүй)
3. Анги удирдсан багш ба сургуулийн нийгмийн ажилтны **тодорхойлолт** тус бүр 1 ширхэг (маягтын дагуу, Хавсралт 2)
4. Улс, аймаг, хот, дүүргийн олимпиад, уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилт, эсвэл спорт, урлагаар гаргасан амжилтыг гэрчлэх **материалын хуулбар** (үүнд зөвхөн сүүлийн 2 жил буюу 2017-2018 оны хичээлийн жил, 2018-2019 оны хичээлийн жилүүдэд гаргасан амжилтыг тооцно. Амжилтын хуулбарыг нотариатаар баталгаажуулах шаардлагагүй)
5. “**Миний ирээдүйн зорилго**” эсхүл “**Монголын ирээдүй миний нүдээр**” сэдвийн хүрээнд компьютер эсвэл гараар Монгол хэл дээр цэвэр гаргацтай бичсэн 500-аас доошгүй үгтэй **эссэ бичлэг**.
6. **Ам бүлийн тодорхойлолт** (Тодорхойлолт дээр гэр бүлийн гишүүд тус бүрийн эрхэлж буй ажлыг тодорхой заах бөгөөд харьяалах нутаг дэвсгэрийн анхан шатны нэгжийн тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажсан байна)
7. **Өрхийн орлогын тодорхойлолт**. Хэрвээ:
  - Эцэг эх, асран хамгаалагч нь ажилладаг бол ажлын газрын тамга тэмдэгтэй цалингийн тодорхойлолт
  - Эцэг эх, асран хамгаалагч тэтгэвэр авдаг бол түүний тэтгэврийн дэвтрийн хуулбар
  - Эцэг эх, асран хамгаалагч нь эрхэлсэн ажилгүй бол харьяа баг, хорооны тодорхойлолт, халамжийн дэвтрийн хуулбар, халамжийн газрын тодорхойлолт
  - Эцэг эх, асран хамгаалагч нь хувиараа ажил эрхэлдэг бол орлого зарлагын цэнхэр дэвтрийн хуулбар,
  - Малчин өрх бол мал тооллогын А дансны хуулбараар тус тус баталгаажуулна.
8. **Сургуулийн албан ёсны тодорхойлолт** буюу албан бичиг. Үүнд тухайн сурагчийн сурлага, нийгмийн идэвх, санаачлага, хувь хүний хандлага, ур чадвар, цаашид сурч хөгжих хүсэл эрмэлзэл, ар гэрийн амьдрал зэргийг дэлгэрэнгүй тодорхойлсон байна. (Хавсралт 3)

**Жич:** Хугацаа хоцроож ирүүлсэн материалыг хүлээн авахгүй бөгөөд хүлээн авсан материалыг буцаан олгохгүй болохыг анхаарна уу.

#### **Сонгон шалгаруулалт:**


- Сонгон шалгаруулалтыг үе шат бүрт томилогдох комисс зохион явуулна. Комиссын бүрэлдэхүүнд ХААН Банкны ажилтнууд, аймаг, сум, дүүргийн төр захиргаа, боловсролын байгууллага болон иргэдийн төлөөлөл багтана. Сонгон шалгаруулалтыг сум-аймаг/дүүрэг-улс гэсэн 3 шатлалаар үндэсний хэмжээнд зохион байгуулна.
- Тэтгэлэгт хамрагдахаар шалгарсан сурагчдад тэтгэлэг хүртэх эрхийн бичгийг гардуулна.
- Эрхийн бичиг гардан авсан сурагчид Ерөнхий шалгалтаа өгч тэнцэн, дотоодын их дээд сургуульд суралцах эрхтэй болсны дараа элссэн сургуулийн томилолтын хуудас, биеийн байцаалтын хуулбарыг үндэслэн ХААН Банк эрхийн бичгийг мөнгөжүүлнэ. /8-р сард/
- Тэтгэлэгт хамрагдахаар шалгарсан сурагч нь дотоодын их дээд сургуульд суралцах эрх авч чадаагүй тохиолдолд ХААН Банк Сан тухайн аймаг, дүүргийн комиссоос ирүүлсэн нэр дэвшигчийн материалаас дахин сонголт хийж, хөтөлбөрт хамрагдах боломжит дараагийн хүүхдийг шалгаруулна.
- Тухайн их дээд сургуулийн төлбөр ямар байхаас үл хамааран ХААН Банк Сангаас заасан мөнгөн дүнг сурагчдад тэтгэлэг болгон олгоно.



**Хавсралт 1**

**ТЭТГЭЛЭГ ХҮСЭГЧИЙН АНКЕТ**

- 1. Ургийн овог: ..... Эцэг/Эх-ийн нэр: ..... Нэр: .....
- 2. Төрсөн огноо: ..... 3. Регистрийн №: ..... 4.Хүйс: .....
- 5. Оршин суугаа хаяг /аймаг, сум, дүүрэг/: .....
- 6. Сургууль: ..... 7. Анги: .....
- 8. Утас: ..... 9. И-Мэйл хаяг: .....
- 10. Фэйсбүүк хаяг: .....



**11. Гэр бүлийн тухай мэдээлэл**

№	Гэр бүлийн гишүүний нэр	Хэн болох	Ажил эрхлэлт /Сургууль	Регистр	Холбоо барих утас

**12. Хэрэв танай гэр бүлд Их дээд сургууль төгссөн эсвэл одоо суралцаж байгаа оюутан байгаа бол сургалтын төлбөрөө ямар хэлбэрээр төлсөн/төлж буй эсэхийг дугуйлна уу.**

- а. Хувиараа
- б. Төрийн сангийн зээл, буцалтгүй тусламж
- в. Гадаад дотоодын байгууллагуудын нэрэмжит тэтгэлэг
- г. Бусад .....

**13. Орхийн орлогын дэлгэрэнгүй мэдээлэл**

- 1 сард ноогдох орлогыг бичих бөгөөд тогтмол цалин, хувиараа болон бусад сувгаар олдог орлогын тооцоолно.
- Улирлын шинж чанартай орлогын нийт дүнг жилийн сард хуваана.
- Мөн түүнчлэн Нийгмийн хамгааллын сангаас олгогддог бүх төрлийн тэтгэвэр тэтгэмжийн мөнгийг орлогод хамааруулан бичнэ/

№	Орлогын төрөл /гэр бүлийн гишүүдийн цалин, тэтгэвэр, тэтгэмж, хувиараа бол эрхэлдэг үйл ажиллагаа, малтай бол тоо толгой/	Сарын орлогын дүн	Тайлбар
Орлого 1			
Орлого 2			
Орлого 3			
Орлого 4			
<b>Нийт Орлого</b>			

**14. Өөр тэтгэлэгт хамрагдахаар өргөдөл өгсөн эсвэл боломжтой эсэх: /Төрийн сангийн зээл, бусад байгууллагын нэрэмжит тэтгэлэг гэх мэт/**

.....

- 15. Цаашид суралцахыг хүсэж буй чиглэл: .....
- 16. Эцэг эхийн утас : .....
- 17. Яаралтай үед холбогдох утас: .....

Дээрх мэдээллийн үнэн зөвийг баталсан: ...../Тэтгэлэг хүсэгчийн гарын үсэг/  
..... /Эцэг эх, асран хамгаалагчийн гарын үсэг/



**ТОДОРХОЙЛОЛТ 1**

Тэтгэлэг хүсэгчийн:

Овог: \_\_\_\_\_

Нэр: \_\_\_\_\_

Тэтгэлэг хүсэгчийн талаар үнэн зөв, шударга мэдээлэл өгнө гэдэгт бид найдаж байна. Дараах асуултуудад хариулсны дараа Үнэлгээний хүснэгтийг бөглөнө үү. Тэтгэлэг хүсэгчийн талаарх нэмэлт мэдээллийг хавсаргаж болно.

**A. Асуултууд**

*1. Тэтгэлэг хүсэгчийг хэдэн жилийн өмнөөс хэрхэн мэдэх вэ?*

*2. Тэтгэлэг хүсэгчийн авъяас чадвар, давуу талыг та юу гэж үнэлдэг вэ?*

*3. Тэтгэлэг хүсэгчийн дутагдал ба сул тал юу вэ?*

*4. Тэтгэлэг хүсэгчийн цаашид сурч боловсрох хүсэл эрмэлзлэлийг та хэрхэн дүгнэх вэ?*

*5. Та тэтгэлэг хүсэгчийг ямар учраас энэхүү тэтгэлэгийг авах үндэслэлтэй гэж үзэж байна вэ?*



**Б. Үнэлгээний хүснэгт**

**Тэтгэлэг хүсэгчийн ур чадварын талаарх Таны үнэлгээ**

Сонгох хариултаа /"+"/ гэж тэмдэглэнэ

**Ур чадварын чиглэл**

маш сайн

Сайн

дунд

хэлж мэдэхгүй байна

1. Манлайлах чадвар

2. Харилцааны чадвар

3. Бусдыгаа уриалах, зохион байгуулах чадвар

4. Тусч, хөдөлмөрч чанар

5. Идэвх санаачлага

6. Сурч боловсрох эрмэлзэл

7. Нийгмийн идэвх

**Тодорхойлсон:**

**Анги удирдсан багш:**

Овог:.....

Нэр:.....

И-мэйл хаяг:.....

Гар утас: .....

Факс:.....

Гарын үсэг \_\_\_\_\_

Огноо \_\_\_\_\_



## ТОДОРХОЙЛОЛТ 2

Тэтгэлэг хүсэгчийн:

Овог: \_\_\_\_\_

Нэр: \_\_\_\_\_

Тэтгэлэг хүсэгчийн талаар үнэн зөв, шударга мэдээлэл өгнө гэдэгт бид найдаж байна. Дараах асуултуудад хариулсны дараа Үнэлгээний хүснэгтийг бөглөнө үү. Тэтгэлэг хүсэгчийн талаарх нэмэлт мэдээллийг хавсаргаж болно.

### А. Асуултууд

*1. Тэтгэлэг хүсэгчийг хэдэн жилийн өмнөөс хэрхэн мэдэх вэ?*

*2. Тэтгэлэг хүсэгчийн авъяас чадвар, давуу талыг та юу гэж дүгнэх вэ?*

*3. Тэтгэлэг хүсэгчийн дутагдал ба сул тал юу вэ?*

*4. Хичээлээс гадуур зохиогддог нийгэм олон нийт, сайн дурын ажилд оролцох идэвхийг хэрхэн дүгнэх вэ? Жишээ дурьдана уу.*

*5. Та тэтгэлэг хүсэгчийг ямар учраас энэхүү тэтгэлэгийг авах үндэслэлтэй гэж үзэж байна вэ?*



**Б. Үнэлгээний хүснэгт**

**Тэтгэлэг хүсэгчийн ур чадварын талаарх Таны үнэлгээ**

Сонгох хариултаа /"+"/ гэж тэмдэглэнэ

Ур чадварын чиглэл	Маш сайн	Сайн	дунд	хэлж мэдэхгүй байна
1. Манлайлах чадвар				
2. Харилцааны чадвар				
3. Бусдыгаа уриалах, зохион байгуулах чадвар				
4. Тусч, хөдөлмөр чанар				
5. Идэвх санаачлага				
6. Сурч боловсрох эрмэлзэл				
7. Нийгмийн идэвх				

**Тодорхойлсон:**

**Сургуулийн нийгмийн ажилтан:**

Овог:.....

Нэр:.....

И-мэйл хаяг:.....

Гар утас:.....

Факс:.....

Гарын үсэг \_\_\_\_\_

Огноо \_\_\_\_\_

**Хавсралт 3****СУРГУУЛИЙН АЛБАН БИЧИГ БУЮУ ТОДОРХОЙЛОЛТ** бичих загвар

Өмнөх жилүүдийн туршлагаас харахад сургуулийн тодорхойлолт буюу албан бичгийг зөвхөн тухайн сургуульд суралцдаг эсэхийг батлах тодорхойлолт гэж ташаа ойлгож байгаа нь харагдаж байна. Тиймээс сургуулийн тодорхойлолт буюу албан бичгийг доорхи зааврын дагуу бичнэ үү.

- Тайлбар:** Сургуулийн албан бичиг буюу тодорхойлолт нь тэтгэлэг хүсэгчийн суралцаж буй сургуулийн албан бланк дээр захирал буюу сургалтын менежер эсхүл хичээлийн эрхлэгчийн гарын үсгээр баталгаажсан тамга тэмдэг бүхий дэлгэрэнгүй албан тоот байна.
- Хэнд хаяглах:** “ХААН Банкны нэрэмжит шинэ оюутны тэтгэлэгт хөтөлбөр 2019-2020” хөтөлбөрийн шалгаруулах комисст
- Хэнээс:** Сургуулийн захирал, сургалтын менежер, хичээлийн эрхлэгч гэх мэт сургуулийн удирдах албан тушаалтнаас
- Агуулга:** Тэтгэлэг хүсэгч-сурагчийн сурлагын амжилт, нийгмийн идэвхи, санаачлага, хувь хүний хандлага, ур чадвар, цаашид сурч хөгжих хүсэл эрмэлзэл, ар гэрийн байдал, ХААН Банкны шинэ оюутны тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах шаардлага зэргийг дэлгэрэнгүй тодорхойлсон байна.
- Тодорхойлолтын хэмжээ:** Нэг нүүрээс ихгүй